

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитын код: САГ-2018/123/СТА-ТӨААТҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

“И.Эс.Эс.Эс Аудит” ХХК-ийн
Захирал: Ц.Сугармаа
Аудитор: Э.Нарангэрэл

Утас: 99151254
99907511

Компанийн хаяг: СБД, 1-р хороо Жамьяан гүний гудамж-5
Ар Монгол Трэвэлийн байр
Цахим шуудан: esss.audit@gmail.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Бүтэц, зохион байгуулалтын талаар	4
2.9.2	Бүтэц, зохион байгуулалтын талаар	4
2.9.3	Түрээсийн зардлын талаар.....	4
2.9.4	Хүний нөөцийн талаар	4
2.9.5	Захиалагчийн хяналтын зардлын талаар	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3	Менежментийн захидал	7
3.1	Бүтэц, зохион байгуулалтын талаар	8
3.2	Бүтэц, зохион байгуулалтын талаар	9
3.3	Түрээсийн талаар.....	10
3.4	Хүний нөөцийн талаар	11
3.5	Захиалагчийн хяналтын тооцоо	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1 АУДИТЫН ТАЙЛАН

1.1 ОРШИЛ

Барилгын хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Барилгын хөгжлийн төвийн захирал Ц.Амарсанаад танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыгтооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилгын хөгжлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Барилгын хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Барилгын хөгжлийн төвийн удирдлага санхүүгийн тайланг НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Барилгын хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 25-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийхээр төлөвлөн тус компанийн захирал Ц.Сугармаа хянан удирдаж, аудитор Э.Нарангэрэл, туслах аудитор Э.Сайнзаяа нар хэрэгжүүлж ажиллав.



Барилгын хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 03/239 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд техникийн хяналт тавих, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах, барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай судалгаа, мэдээллээр Барилга, хот байгуулалтын яам, эрх бүхий байгууллагыг хангах зорилго бүхий барилгын салбарын мэргэжлийн төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилго нь “Барилгын тухай хууль”, “Орон сууцны тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, барилгын салбарын талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилготой.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.


Аудитаар Барилгын хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоож, тухайн байгууллагын дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансуудад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Барилгын хөгжлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн “Интерактив Би Ай” ХХК-ийн Diamond програмыг ашиглаж, санхүүгийн тайланг гаргаж байна.

Барилгын хөгжлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ гарсан тул аудитыг шууд гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-2/

ТАБ-СТА-А-4 маягтыг ашиглан материаллаг байдлын суурийг ТАБ-СТА-А-4 маягтыг ашиглан төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг нийт орлогын дүнгээс материаллаг байдлыг 1 хувиар буюу 43.6 сая төгрөгөөр тогтоосон. Энэ нь гүйцэтгэлийн шатанд өөрчлөгдөөгүй болно.



1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Барилгын хөгжлийн төвд хяналт шинжилгээ, хуулийн алба ажилладаг бөгөөд энэхүү бүтцэд дотоод аудитор 2017 оны 10 сараас эхэлж ажиллаж эхэлсэн байна. Цаашид дотоод аудиторын ажиллах дүрэм журмыг боловсруулж мөрдөж ажиллах нь зүйтэй.

1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Барилгын хөгжлийн төвийн 2017 оны эдийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 186 дугаар тогтоолоор баталжээ.

Энэхүү тогтоолоор нийт орлогыг 4,610.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс захиалагчийн хяналтын орлого 1,503.5 сая төгрөг, сургалтын орлого 420.2 сая төгрөг, зураг төсөл, магадлалын орлого 1,350.0 сая төгрөг, нормчлолтой холбоотой орлого 345.6 сая төгрөг, лабораторийн орлого 245.0 сая төгрөг, тусгай зөвшөөрөл болон бүтээгдэхүүн баталгаажуулалтын орлого 532.3 сая төгрөг, бусад орлого 214.0 сая төгрөг байна.

Гүйцэтгэлээр 4,538.9 сая төгрөгийн орлого олж орлогын гүйцэтгэл 98.4 хувийн биелэлттэй байна.

Нийт зардлыг 4,561.9 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 4,007.8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалд 2,333.4 сая төгрөгийн, захиалагчийн хяналт хийхэд зорилж, 196.3 сая төгрөгийн, элэгдлийн зардалд 605.9 сая төгрөгийн, ажиллагсадын нийгмийн хамгааллын зардалд 102.3 сая төгрөг, барилга хот байгуулалтын салбарын хурал, зөвөлгөөн, семинар зохион байгуулахад 156.2 сая төгрөг, бусад зардал 613.3 сая төгрөгийг зарцуулж, зардлыг 554.1 сая төгрөгөөр буюу 12.3 хувиар хэмнэж ажиллажээ.


1.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим бүртгэл хөтөлж, “Шилэн дансны журам”-ын дагуу 2017 онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мэдүүлсэн үзүүлэлт давхардсан тоогоор 253, нийт 4,396.7 сая төгрөг, зарлагын мөнгөн гүйлгээний мэдүүлсэн давхардсан тоогоор 111, нийт 1,191.7 сая төгрөг нийт 5,588.4 сая төгрөгийн гүйлгээг тайлагнасан байна.

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 17, 21, 22 дугаар хавсралтуудыг хуулийн хугацаанд тайлагнаж <https://www.shilendans.gov.mn> <http://barilga.gov.mn/> цахим хуудсанд байршуулсан байна.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 21 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 21 нарийвчилсан гэсэн, сорилт хийж гүйцэтгэв.



1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.9.1 Бүтэц, зохион байгуулалтын талаар

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 215 дугаар тушаалаар Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэр гарч Төрийн бус байгууллагуудын түншлэл “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн байгууллагад барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт явуулах эрхийг олгожээ. Ингэхдээ сургалтын хөтөлбөрийг 2018 оны 1 сарын 10-ны дотор сургалтын хөтөлбөрөө батлуулах, сургалт хийх нөхцөлөөр хангах, мэдээллийн санг хамтран ашиглахаар удирдлагуудад даалгасан. Оны эхний гурван сарын байдлаар сургалт хийгдээгүй, төрийн өмчийн сургалтын баазыг чухам яаж ашиглах талаар тодорхойгүй, сургалтын хөтөлбөр батлагдаагүй байгаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдуулсан

Шийдвэрлэсэн нь: Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар төрийн бус байгууллага сургалт явуулах чиг үүргийг шилжүүлсэнтэй холбоотойгоор энэхүү ТББ-ын сургалт явуулах нөхцөл, сургалтын төлбөрийн асуудал, сургалтын баталгаа зэрэг асуудлыг тодорхой болгох талаар дээд байгууллагын шийдвэрийг гаргуулах

1.9.2 Бүтэц, зохион байгуулалтын талаар

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 216 дугаар тушаалаар Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэр гарч барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд Төрийн бус байгууллагуудын түншлэл болох “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-д гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэр гаргажээ. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 650 дугаар тогтоолоор тус төвийн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа сургалт болон тусгай зөвшөөрлөөс орох орлогын төлөвлөгөөг хэвээр нь баталсан

Шийдвэрлэсэн нь: Барилга, хот байгуулалтын сайдын тушаалуудын холбогдох заалтууд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэртэй зөрчилдөж байгаа тул төсөв хөрөнгийн талаарх оновчтой шийдвэрийг гаргуулах арга хэмжээ авч ажиллах


1.9.3 Түрээсийн зардлын талаар

Барилгын хөгжлийн төвийн байранд “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”, “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” гэсэн төрийн байгууллагууд гэрээний дагуу 27-199.4 мкв оффисын зориулалтаар төрийн өмчийг ашиглаж байна. Аудитын явцад гэрээний гүйцэтгэлийг үзэхэд тайлант жилд “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” нь 827.3 мянган төгрөгийг, “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл” 2,456.1 мянган төгрөгийг төлөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”, “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар”-ын удирдлагууд болон тус төвийн захиралтай хийсэн гэрээний дагуу үүргээ биелүүлж, түрээсийн төлбөрийн дутууг бүрэн төлж, өр барагдуулах арга хэмжээ авч, төлбөрийг төлүүлэх

1.9.4 Хүний нөөцийн талаар

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий нягтлан бодогч Ж.Салонгэ, мэргэжлийн нягтлан бодогч бус бөгөөд санхүү, төсөв хөрөнгө болон санхүүгийн тайланд гарын



үсэг зурж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3-т заасан “Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яам зөвшөөрснөөр байгууллагын захирал томилно”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт хүргүүлсэн 2018 оны А1/350 тоот албан даалгаварт мэргэшсэн нягтлан бодогч хүнийг ерөнхий нягтлан бодогчоор томилж ажиллуулах

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж боловсон хүчнийг сонгон шалгаруулж томилох

2.9.5 Захиалагчийн хяналтын зардлын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолоор “Барилга захиалагчийн албаны талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан бөгөөд энэхүү тогтоолоор “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжид захиалагчийн хяналт хийх чиг үүрэг бүхий Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэргэдэх Барилга захиалагчийн алба, товчоог татан буулгаж, тэдгээрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байсан инженерүүдийг орон тоо, цалингийн сангийн хамт “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлсэн байна. Гэтэл зарим салбарын яамдууд түүгээрээ барьж байгаа барилгын гүйцэтгэлд хяналт тавих, төсөв хөрөнгийг зарцуулах асуудал гарч байна. Тухайлбал: Эрүүл мэндийн яам тайлант жилд хөрөнгө оруулалтын төсвөөс захиалагчийн хяналт хийсэн зардлыг тухайн байгууллагатай тооцоо хийж 229,8 сая төгрөгийг өгөхөөр тооцсон боловч тайлант хугацаанд Барилгын хөгжлийн төвийн дансанд төвлөрүүлээгүй


Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу тайлант жилд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилгын явцад хийсэн хяналтын зардал 229,8 сая төгрөгийг төвлөрүүлэн авч орлогоор бүртгэх, цаашид захиалагчийн хяналтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, тооцоог хагас, бүтэн жилээр хийж тайланд тусгаж байх

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 215, 216 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор “Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” шийдвэр гарсан.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх чиг үүргийг барилгын салбарын төрийн бус байгууллага /8/-уудын түншлэлийг төлөөлж “Монголын барилгын үндэсний ассоциаци”, “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагуудаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх шийдвэр гаргаж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус төвийн 2018 оны төсөв төлөвлөгөөг нийт 1.0 тэрбум гаруй төгрөгийн орлогын төлөвлөгөөг баталсан. Ийнхүү чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх болсноор тус байгууллагын 2018 оны зорилтот түвшингийн биелэлт, орлого тэр хэмжээгээр буурах бөгөөд энэ талаар дээрх Засгийн газрын болон Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэрүүдэд зохицуулсан өрх зүйн зохицуулалт алга байна.



1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Барилгын хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг шалгаж, дүгнэлт гаргана.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Тайлант жилд тус төвийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой 2, түрээсийн төлбөрийн нийт 3.2 сая төгрөгийг төлөөгүй, хүний нөөцтэй холбоотой 1, захиалагчийн хяналтын зардлын нийт 229.8 сая төгрөгийг төвлөрүүлэх гэсэн 5 зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв.

1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Барилгын хөгжлийн төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч, байгууллагын үйл ажиллагааны онцлогыг гүйцэд тусгаагүйг шинэчлэх, 9.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй, элэгдлээрээ анхны хөрөнгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх, эксперт хийж буй мэргэжилтнүүдийн гэрээ, тэдгээрийн тооцоолол, баримтын бүрэн бүтэн байдалд санхүүгийн албанаас хяналт тавих гэсэн 4 зөвлөмж өгч, зөвлөмжийг 100 хувь биелүүлсэн байна.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн нийт орлогын дүнгээс 1 хувиар тооцож 43.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Барилгын хөгжлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Барилгын хөгжлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Барилгын хөгжлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



2.1 БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 215 дугаар тушаалаар Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэр гарч Төрийн бус байгууллагуудын түншлэл “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн байгууллагад барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт явуулах эрхийг олгожээ.

Ингэхдээ сургалтын хөтөлбөрийг 2018 оны 1 сарын 10-ны дотор сургалтын хөтөлбөрөө батлуулах, сургалт хийх нөхцөлөөр хангах, мэдээллийн санг хамтран ашиглахаар удирдлагуудад даалгасан. Оны эхний 3 сарын байдлаар сургалт хийгдээгүй, төрийн өмчийн сургалтын баазыг чухам яаж ашиглах талаар тодорхойгүй, сургалтын хөтөлбөр батлагдаагүй байгаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдуулахад хүргэж байна

ҮАГ-ын зөвлөмж

Энэхүү Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар төрийн бус байгууллага сургалт явуулах чиг үүргийг шилжүүлсэнтэй холбоотойгоор энэхүү ТББ-ын сургалт явуулах нөхцөл, сургалтын төлбөрийн асуудал, сургалтын баталгаа зэрэг асуудлыг тодорхой болгох талаар дээд байгууллагын шийдвэрийг гаргуулах


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Бүтэц зохион байгуулалтын асуудал оновчтой бус байх

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, төр санхүүгийн байгууллагад танилцуулсан болно.



2.2 БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 216 дугаар тушаалаар Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэр гарч барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд Төрийн бус байгууллагуудын түншлэл болох “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-д гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэр гаргажээ. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 650 дугаар тогтоолоор тус төвийн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа сургалт болон тусгай зөвшөөрлөөс орох орлогын төлөвлөгөөг хэвээр нь баталжээ.

ҮАГ-ын зөвлөмж

Иймд Барилга, хот байгуулалтын сайдын тушаалуудын холбогдох заалтууд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэртэй зөрчилдөж байгаа тул төсөв хөрөнгийн талаарх оновчтой шийдвэрийг гаргуулах арга хэмжээ авч ажиллах


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Байгууллагын бүтэц зохион байгуулалт оновчтой бус байх

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, төрийн хүүдийн байршиланд танилцуулсан болно



2.3 ТҮРЭЭСИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Барилгын хөгжлийн төвийн байранд “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”, “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” гэсэн төрийн байгууллагууд гэрээний дагуу 27-199.4 мкв оффисын зориулалтаар төрийн өмчийг ашиглах гэрээ хийж ажиллаж байна. Аудитын явцад гэрээний гүйцэтгэлийг үзэхэд тайлант жилд “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” нь 0.8 сая төгрөг, “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл” 2,4 сая төгрөгийг тус тус төлөөгүй зөрчил илэрлээ.

ҮАГ-ын зөвлөмж

“Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”, “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар”-ын удирдлагууд болон тус төвийн захиралтай хийсэн гэрээний дагуу үүргээ биелүүлж, түрээсийн төлбөрийн дутууг бүрэн төлж, өр барагдуулах арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Түрээсийн төлбөр төлөөгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын удирдлага, танилцуулсан болго. бүртгэлийг үйлчлүүлэгчийн санхүүгийн ажиглалтад ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01 **ЗӨРЧИЛГҮЙ**
САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий нягтлан бодогч Ж.Сэлэнгэ мэргэшсэн нягтлан бодогч бус бөгөөд санхүү, төсөв хөрөнгө болон санхүүгийн тайланд гарын үсэг зурж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3-т заасан “Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яам зөвшөөрснөөр байгууллагын захирал томилно”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт хүргүүлсэн 2018 оны А1/350 тоот албан даалгаварт мэргэшсэн нягтлан бодогч хүнийг ерөнхий нягтлан бодогчоор томилж ажиллуулах гэснийг тус тус зөрчиж байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж боловсон хүчнийг сонгон шалгаруулж томилох

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хуулийг мөрдөж ажиллаагүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



2.5 ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ТООЦОО

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 93 дугаар тушаалаар “Барилга захиалагчийн албаны талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан бөгөөд энэхүү тогтоолоор “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжид захиалагчийн хяналт хийх чиг үүрэг бүхий Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэргэдэх Барилга захиалагчийн алба, товчоог татан буулгаж, тэдгээрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байсан инженерүүдийг орон тоо, цалингийн сангийн хамт “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлсэн байна. Гэтэл зарим салбарын яамдууд түүгээрээ барьж байгаа барилгын гүйцэтгэлд хяналт тавих, төсөв хөрөнгийг зарцуулах асуудал гарч байна. Тухайлбал: Эрүүл мэндийн яам тайлант жилд хөрөнгө оруулалтын төсвөөс захиалагчийн хяналт хийсэн зардлыг тухайн байгууллагатай тооцоо хийж 229,8 сая төгрөгийг өгөхөөр тооцсон боловч тайлант хугацаанд өгөөгүй зөрчил илэрлээ.

ҮАГ-ын зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу тайлант жилд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилгын явцад хийсэн хяналтын зардал 229,871.3 мянган төгрөгийг төвлөрүүлэн авч орлогоор бүртгэх, цаашид захиалагчийн хяналтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, тооцоог хагас, бүтэн жилээр хийж тайланд тусгаж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хуулийг мөрдөж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлтүүд	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,137,172,541.55	4,599,391,806.42
Дансны авлага	28,661,505.54	34,154,555.03
Татвар, НДШ-ийн авлага	24,212.68	
Бараа материал	162,511,464.70	155,324,391.91
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,328,369,724.47	4,788,870,753.36
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	5,495,923,685.18	4,144,010,066.50
Биет бус хөрөнгө	19,687,299.92	70,295,936.17
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,515,610,985.10	4,214,306,002.67
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,843,980,709.57	9,003,176,756.03
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	599,579,390.87	1,048,431,134.97
Цалингийн өглөг	412,386.82	
Татварын өр	22,685,865.91	54,574,711.99
НДШ-ийн өглөг		942,719.19
Урьдчилж орсон орлого	18,774,000.00	42,406,400.00
Бусад богино хугацаат өр төлбөр	1,045,050,550.23	1,142,635,663.96
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,686,502,193.83	2,288,990,630.11
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн нийт дүн	1,686,502,193.83	2,288,990,630.11
Эздийн өмч		
Төрийн өмч	8,159,338.00	8,159,338.00
Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
Эздийн өмчийн бусад хэсэг	5,594,406,006.64	4,708,163,740.03
Хуримтлагдсан ашиг	1,359,433,656.10	1,802,383,532.89
Эздийн өмчийн дүн	7,157,478,515.74	6,714,186,125.92
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	8,843,980,709.57	9,003,176,756.03



3.2 Аудит хийгдсэн ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	4,095,149,892.89	4,361,884,764.95
Борлуулалтын өртөг	19,689,085.39	28,725,860.61
Нийт ашиг (алдагдал)	4,075,460,807.50	4,333,158,904.34
Хүүгийн орлого	110,295,221.47	177,073,144.35
Ерөнхий ба удирдлагын зардал	4,453,544,600.37	3,976,116,323.88
Санхүүгийн зардал		
Бусад зардал	1,612,800.00	2,448,940.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	6,361,985.72	(516,194.61)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(263,039,385.68)	531,150,590.20
Орлогын татварын зардал	11,029,522.15	53,115,059.01
Татварын дараах ашиг (алдагдал)	(274,068,907.83)	478,035,531.19
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(274,068,907.83)	478,035,531.19



3.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	5,580,484,175.95	2,069,635,186.49	7,853,758,215.44
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	5,580,484,175.95	2,069,635,186.49	7,853,758,215.44
4	Бусад дэлгэрэнгүй орлого					
5	Өмчид гаргасан өөрчлөлт				7,060,734.90	7,060,734.90
6	Зарласан ногдол ашиг					
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(274,068,907.83)	(274,068,907.83)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	5,594,406,006.64	1,359,433,656.10	7,157,478,515.74
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	5,594,406,006.64	1,359,433,656.10	7,157,478,515.74
12	Бусад дэлгэрэнгүй орлого			17,722,222.10		17,722,222.10
13	Өмчид гаргасан өөрчлөлт			(903,964,488.71)	33,143,311.40	(870,821,177.31)
14	Зарласан ногдол ашиг					
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	4,708,163,740.03	1,802,383,532.89	6,714,186,125.92



3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	6,485,599,010.98	7,309,310,577.63
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	5,221,250,454.71	6,148,636,570.67
Бусад мөнгөн орлого	1,264,348,556.27	1,160,674,006.96
Мөнгөн зарлагын дүн (-)	(6,557,548,560.14)	(5,832,802,446.46)
Ажиллагчдад төлсөн	(2,001,820,484.55)	(1,610,946,648.84)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(724,073,619.96)	(654,473,229.67)
Бараа материал худалдан авахад төлсөн	(2,934,307,464.42)	(2,657,945,125.86)
Ашиглалтын зардалд төлсөн	(76,903,188.29)	(41,381,304.88)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	354,111,746.76	(12,216,447.03)
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	(338,300,169.88)	(342,800,208.57)
Даатгалын төлбөрт төлсөн	(5,290,000.00)	(3,289,530.00)
Бусад мөнгөн зарлага	(830,965,379.80)	(509,749,951.61)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(71,949,549.16)	1,476,508,131.17
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	109,597,768.88	177,073,144.35
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Хүлээн авсан хүүний орлого	109,597,768.88	177,073,144.35
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	(12,153,914.00)	(190,845,816.04)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(12,153,914.00)	(190,845,816.04)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	97,443,854.88	(13,772,671.69)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	8,597,308.32	1,203,259.21
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	8,597,308.32	1,203,259.21
Мөнгөн зарлагын дүн (-)	(2,235,322.60)	(1,719,453.82)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(2,235,322.60)	(1,719,453.82)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,361,985.72	(516,194.61)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	31,856,291.43	1,462,219,264.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,105,316,250.11	3,137,172,541.55
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,137,172,541.55	4,599,391,806.42

